



2019 он 05 сар 31 өдөр



2019 он 05 сар 31 өдөр

## НИЙТИЙН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛД СУУРИЛУУЛСАН ХЯНАЛТЫН КАМЕРЫГ АШИГЛАХ ЖУРАМ

Улаанбаатар хот

### Нэг. Нийтлэг үндэслэл.

1.1. Энэхүү журмын зорилго нь Нийтийн тээврийн үйлчилгээний газрын бүртгэлийн санд байгаа угсраа болон их, дунд багтаамжийн автобус, троллейбусанд суурилуулсан хяналтын камер, холбогдох тоног төхөөрөмж (Цаашид хамтад нь “камер” гэх)-ийн ашиглалт, хэвийн найдвартай үйл ажиллагааг хангаж, жолооч, шалгагч нарын өдөр тутмын үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах, нийтийн тээврийн хэрэгсэлтэй холбогдсон зам тээврийн осол, халаасны хулгайн болон бусад төрлийн гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, тэдгээрээс урьдчилан сэргийлэхэд оршино.

1.2. Энэхүү журам нь Автотээврийн тухай, Зөрчлийн тухай, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль болон холбогдох бусад хууль, дүрэм, стандартын хүрээнд нийтийн тээврийн хэрэгсэлд суурилуулсан хяналтын камерыг ашиглах харилцааг зохицуулна.

### Хоёр. Хамрах хүрээ

2.1. Нийтийн тээврийн үйлчилгээний газрын бүртгэлийн санд бүртгэгдэж “Удирдлага, мэдээллийн болон цахим төлбөрийн систем”-ийн тоног төхөөрөмж суурилуулсан бүх автобус, троллейбус /цаашид хамтад нь “тээврийн хэрэгсэл” гэх/ хамаарна.

### Гурав. Хяналтын камер, түүнд тавигдах шаардлага

3.1. Энэхүү журмын 2.1-д заасан тээврийн хэрэгслийн дотор талд дараах 4 төрлийн камер байрлана.

3.1.1. Тээврийн хэрэгслийн урд талд салхины шилэнд ойр байрлах гадна хөдөлгөөнийг хянах 1 ширхэг камер;

3.1.2. Зорчигчийн заалны хойд хэсэгт урагш харан байрлах доторх хөдөлгөөнийг хянах 1 ширхэг камер;

3.1.3. Зорчигчийн заалны баруун урд хэсэгт хойш харан байрлах доторх хөдөлгөөнийг хянах 1 ширхэг камер;

3.1.4. Жолоочийн бүхээгийн дотор талд байрлах жолоочийн хөдөлгөөн, карт унших төхөөрөмжийг хянах 1 ширхэг камер.

3.2. Дээрх камерууд нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

3.2.1. Энэхүү журмын 3.1.1-д заасан камер нь тухайн тээврийн хэрэгсэл 60 км/ц хүртэл хурдтай явахад гадаад орчны бичлэг хийх, нийтийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд саад учруулж замналын зогсоолд зогссон болон 1 дүгээр эгнээгээр зорчсон

автомашины зөрчлийн зураг авалтыг богино хугацаанд хийх чадвартай (линз нь уг тээврийн хэрэгслээс 15 м дотор байгаа тээврийн хэрэгслийн улсын дугаарыг таних боломжтой) байх;

3.2.2. Журмын 3.1.2, 3.1.3-д заасан камер нь Монгол улсын стандартын нөхцөл шаардлагад нийцсэн (хүний царай танигдахуйц) байх;

3.2.3. Энэхүү журмын 3.1.4-д заасан камер нь тээврийн хэрэгсэлд орж ирж буй зорчигчийн нүүр танигдахуйц, зорчигчийн карт дарах үйлдэл, жолоочийн хийж буй үйлдэл тод харагдахуйц чанартай бичдэг байх.

3.3. Дээрх камеруудын дүрсний нягтаршил хамгийн багадаа 720 мега пиксел байна.

3.4. Дээрх камеруудын бичигч төхөөрөмж нь тасралтгүй ажиллаж 128GB-аас багагүй багтаамжтай хард диск /hard disk/, эсвэл мемори карт /memory/-тай байх ба багтаамж дүүрэхэд хамгийн эхний бичлэгийг устгах бөгөөд эхний бичлэг 10-аас доошгүй хоногийн дараа устдаг байна.

3.5. Камерууд нь онлайн горимд ажиллах боломжтой байх.

### **Дөрөв. Нийтийн тээврийн үйлчилгээний газрын эрх, үүрэг**

#### **4.1. Нийтийн тээврийн үйлчилгээний газар дараах эрх эдэлнэ. Үүнд:**

4.1.1. Нийтийн тээврийн хэрэгсэлд суурилагдсан камер, тоног төхөөрөмж, програм хангамж чанарын шаардлага хангахгүй болж хэвийн үйл ажиллагаа алдагдсан тохиолдолд сайжруулах талаар Улаанбаатар смарт карт ХХК-д шаардлага тавих;

4.1.2. Камерт бичигдсэн мэдээллийг нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгжүүдээс авах.

#### **4.2. Нийтийн тээврийн үйлчилгээний газар дараах үүрэг хүлээнэ. Үүнд:**

4.2.1. Камерын системийг хянан ажиллах Автотээврийн хяналтын улсын байцаагчийг тогтмол ажиллуулж, даваа гараг бүрийн өглөөний шуурхайд гарсан зөрчлийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээг нэгтгэн, цаашид хэрэгжүүлэх ажлын талаар холбогдох дээд газруудад танилцуулж, шийдвэр гаргуулах;

4.2.2. Нийтийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд саад учруулж замналын зогсоолд зогссон болон 1 дүгээр эгнээгээр зорчсон автомашины зөрчлийн фото зураг, бичлэгийн дагуу зохих арга хэмжээ авхуулах талаар Тээврийн цагдаагийн алба, Улаанбаатар хотын Замын хөдөлгөөний удирдлагын төвд хүргүүлж холбогдох арга хэмжээ тооцуулж байх;

4.2.3. Тээврийн хэрэгслүүдийг оношилгоонд ороход нь хяналтын камерын хэвийн ажиллагаа, бүрэн бүтэн байдлыг шалгах.

### **Тав. Улаанбаатар смарт карт ХХК-ийн эрх, үүрэг**

#### **5.1. Улаанбаатар смарт карт ХХК нь дараах эрх эдэлнэ. Үүнд:**

5.1.1. Камерын ашиглалт, арчлалт, хамгаалалтыг сайжруулах, зөв зохистой ашиглах талаар нийтийн тээврийн үйлчилгээний аж ахуйн нэгж, байгууллагуудад шаардлага тавих;

5.1.2. Камерын суурилуулалт, засвар үйлчилгээг өөрөө эсхүл туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэх;

5.1.3. Камер болон түүнтэй холбогдох тоног төхөөрөмж эвдэрсэн эсхүл механик гэмтэл учирсан, тохиолдолд (буруутай этгээдийг тогтоон) тухайн аж ахуйн нэгжээс засварлахад шаардлагатай эд ангийн төлбөрийг гаргуулах эсхүл тухайн камер засварлах боломжгүй болсон тохиолдолд камерийн өртгийг гаргуулан авах.



## 5.2. Улаанбаатар смарт карт ХХК нь дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

5.2.1. Тээврийн хэрэгсэлд камерын линзэнд нарны гэрэл шууд тусахгүй байдлаар камеруудыг байрлуулж, унаж доргих, гадна хүчин зүйлээс шалтгаалах эрсдэлээс урьдчилан сэргийлэн бэхэлж суурилуулан, хэвийн ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ;

5.2.2. Нийтийн тээврийн үйлчилгээний тээврийн хэрэгсэлд суурилуулсан камерт учирсан эвдрэл, гэмтэл, саатал гарсан тохиолдолд гэмтлээс шалтгаалан 48 цагийн дотор засварлаж хэвийн, найдвартай ажиллагааг хангах;

5.2.3. Тээврийн хэрэгсэлд суурилуулсан камер, холбогдох тоног төхөөрөмжийн өртгийг баталж эвдрэл, гэмтэл гарсан тохиолдолд шалтгааныг тодорхойлж буруутай этгээдээр нөхөн төлүүлж хэвийн үйл ажиллагаанд оруулах;

5.2.4. Тав буюу түүнээс дээш жил ашигласан камерыг шинэчлэх, камерын програм хангамжийг сайжруулж байх;

5.2.5. Баталсан хуваарийн дагуу нийтийн тээврийн хэрэгслүүдэд суурилуулсан камер, холбогдох тоног төхөөрөмжүүдэд улиралд 1-ээс доошгүй удаа үзлэг хийж эвдрэл, гэмтлийг засварлан, хэвийн ажиллагааг хангах;

5.2.6. Нийтийн тээврийн үйлчилгээний аж ахуйн нэгж, байгууллагуудыг онлайн, оффлайн горимд ажиллах камер болон холбогдох тоног төхөөрөмжийн сэлбэгийн нөөц хангах;

5.2.7. Нийтийн тээврийн хэрэгсэлд суурилуулсан камер болон холбогдох тоног төхөөрөмжийг (хард, мемори лацдахаас бусад) бүрэн лацдах (лац найдвартай, баталгаажсан байх) бөгөөд лацадсан талаарх баримтыг аж ахуйн нэгж, байгууллагад мэдэгдэж баримт үйлдэж, баталгаажуулан хүлээлгэн өгөх;

5.2.8. Засварын дуудлага өгснөөс хойш 24 цагийн дотор очих бөгөөд очсон эсэх баримтыг бүрдүүлэх, засварласны дараа мэдээллийг тогтмол жагсаалтаар үйлдэж байх;

5.2.9. Тээврийн хэрэгслүүдийг оношилгоонд оруулах хугацаанд Улаанбаатар смарт карт ХХК нь камерын ажиллагааг шалгах ажилтанг томилж ажиллуулах;

5.2.10. Лац хөндсөн тухай тэмдэглэл, баримтыг үйлдэх, тогтмол хөтлөх;

5.2.11 Нийтийн тээврийн хэрэгсэлд суурилуулсан камер болон холбогдох тоног төхөөрөмжийг ашиглах талаар сургалт зохион байгуулах.

### **Зургаа. Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүрэг**

#### 6.1.Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллага нь дараах эрх эдэлнэ. Үүнд:

6.1.1. Энэхүү журамд заасан үүргээ биелүүлэхийг Нийтийн тээврийн үйлчилгээний газар, Улаанбаатар смарт карт ХХК-аас шаардах;

6.1.2. Камерын бичлэгийг хуулан өгөх, хард диск, мемори картын мэдээллийг холбогдох эрх бүхий байгууллагад хүлээлгэн өгөх тохиолдолд зөвхөн хард диск, мемори картын лацыг хөндөх.

#### 6.2. Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллага дараах үүрэг хүлээнэ.

6.2.1. Улаанбаатар смарт карт ХХК-аас суурилуулсан камерын бүрэн бүтэн байдал, ажиллагааг шалгаж, ашиглалтад хүлээн авах;

6.2.2. Камеруудын линзний бохирдлыг цэвэрлэх, камерын харах өнцөг, бичлэг хийх чиглэлд өөрчлөлт орсон эсэх, бүрэн бүтэн байдал болон хэвийн ажиллаж байгаа эсэхэд тогтмол хяналт тавих, эвдрэл, гэмтэл, саатал илэрсэн даруйд Улаанбаатар смарт карт ХХК- байгууллагад мэдэгдэн /24 цагаас хэтрүүлэхгүй/ засварлуулах талаар арга хэмжээ авах;



6.2.3. Камерын бичлэг багадаа 10 хоногийн турш хадгалагдах тул Нийтийн тээврийн үйлчилгээний газраас бусад шалгах эрх бүхий аж ахуйн нэгж, байгууллагуудаас албан бичгээр гаргасан хүсэлтийг үндэслэн ажлын 1 өдөрт багтаан, цагдаагийн байгууллагын ажилтны ажлын А серийн үнэмлэхийг үндэслэн нэн даруй хуулбарлан цахим хэлбэрээр хүлээлгэн өгөхөөс гадна бүртгэл хөтлөх, мэдээллийн нууцлал аюулгүй байдлыг хангах;

6.2.4. Хард диск, мемори картыг лацадсан, лацыг хөндсөн тухай тэмдэглэл, баримтыг үйлдэх, тогтмол хөтлөх;

6.2.5. Камерын ашиглалт, хамгаалалтын талаар дотооддоо мөрдөх журмыг боловсруулан баталж мөрдүүлэх бөгөөд хариуцсан ажилтантай байх;

6.2.6. Камер түүний дагалдах тоног төхөөрөмжийн засварын төлбөрийг холбогдох баримт актыг үндэслэн, нэхэмжлэлийн дагуу ажлын 10 хоногийн дотор шилжүүлэх;

6.2.7. Камерын засвар үйлчилгээ, лацадсан эсэхэд хяналт тавьж, энэ тухай Улаанбаатар смарт карт ХХК-тай хамтран баримт үйлдэх бөгөөд энэхүү үйл ажиллагааг хийхэд хариуцсан ажилтанг байлцуулах;

6.2.8. Жолооч болон шалгагч шаардлага тавьж байгаа, зорчигч хөлсөө картаар төлж байгаа эсэхэд тогтмол хяналт тавьж, шаардлагатай бичлэгийг хуулбарлан Нийтийн тээврийн үйлчилгээний газарт ирүүлэх;

6.2.9. Камер болон түүний дагалдах хэрэгсэл /хард диск гэх мэт/-д санаатайгаар механик гэмтэл учруулсан, алга болгосон тохиолдолд хохирлыг барагдуулах;

6.2.10. Камерын бичлэгийг шүүх, хуулбарлан авах тохиолдолд хард диск, мемориг авах бөгөөд энэхүү тохиолдолд нөөц хард диск, мемориг зөрүүлэн хийх шаардлагатай тул аж ахуйн нэгж, байгууллага өөрийн хөрөнгөөр дотооддоо нөөцийг (гаралтын тээврийн хэрэгслийн тоонд харьцуулан 10-аас доошгүй хувьд) бүрдүүлсэн байна.

6.2.11 Нийтийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд саад учруулж замналын зогсоолд зогссон болон 1 дүгээр эгнээгээр зорчсон автомашины зөрчлийн фото зураг, бичлэгийн дагуу зохих арга хэмжээ авхуулах талаар Улаанбаатар хотын Замын хөдөлгөөний удирдлагын төвд хүргүүлж холбогдох арга хэмжээ тооцуулж байх;

## **Долоо. Цагдаагийн байгууллагын эрх, үүрэг**

### **7.1. Цагдаагийн байгууллага дараах эрх эдэлнэ.**

7.1.1. Энэ журмын 2.1-т заасан камер суурилуулсан тээврийн хэрэгслүүдийн бичлэгийг хуулбарлан авах;

7.1.2. Камерын ажиллагаанд хяналт шалгалт хийх, сургалт зохион байгуулах;

7.1.3. Нийтийн тээврийн хэрэгсэлд үйлдэгдэж байгаа болон түүнтэй холбоотой гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, суурилагдсан камерын хэвийн үйл ажиллагааг хангуулах зорилгоор холбогдох байгууллагад мэдэгдэл, шаардлага хүргүүлж, биелэлтийг ирүүлээгүй тохиолдолд хуульд заасан хариуцлага тооцох;

### **7.2. Цагдаагийн байгууллага дараах үүрэг хүлээнэ.**

7.2.1. Бичлэг шүүлгэх, хуулбарлан авахад албан бичгээр гаргасан хүсэлт, зайлшгүй тохиолдолд тухайн албан хаагч ажлын А серийн үнэмлэхээ үзүүлж авч байх;

7.2.2. Жолооч, шалгагч, Автотээврийн хяналтын улсын байцаагч болон холбогдох ажилтнуудын шаардлагыг биелүүлэхээс татгалзсан, биед халдсан, эрүүл мэндэд хохирол учруулсан этгээдийг шалгаж, хэрхэн шийдвэрлэгдсэн талаар эргэн мэдэгдэж байх.

## **Найм. Шалгагчийн асуудал хариуцсан аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүрэг**

### **8.1. Шалгагчийн асуудал хариуцсан аж ахуйн нэгж, байгууллага дараах эрх эдэлнэ.**

8.1.1. Өөрийн хяналт тавихаар хариуцсан чиглэлүүдийн тээврийн хэрэгсэлд суурилагдсан хяналтын камерыг онлайн горимд харах эрхийг авч, үйлчилгээнд хяналт тавих;

8.1.2. Эвдрэл, сааталтай буюу ажиллагаагүй болсон камерыг засахыг шаардах;



8.1.3. Шаардлагатай тохиолдолд албан бичгээр хүсэлт гаргаж хяналтын камерын бичлэгийг авах.

## 8.2. Шалгагчийн асуудал хариуцсан хариуцсан аж ахуйн нэгж, байгууллага дараах үүрэг хүлээнэ.

8.2.1. Онлайн хяналтын камерын ажиллагаанд байнгын хяналт тавих бөгөөд хариуцсан ажилтнуудтай байх;

8.2.2. Тээврийн хэрэгслийн хяналтын камерын бичлэгийг шалгаж, зөрчлийн бичлэгийг Автотээврийн хяналтын улсын байцаагчид ажлын 3 хоногийн дотор шилжүүлэн, зөрчлийг бууруулан ажиллах;

8.2.3. Камерын бичлэгийг шүүх, шилжүүлэх, ашиглах талаар дотооддоо үйл ажиллагааны журам боловсруулан баталж, мөрдүүлнэ.

8.2.4 Нийтийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд саад учруулж замналын зогсоолд зогссон болон 1 дүгээр эгнээгээр зорчсон автомашины зөрчлийн фото зураг, бичлэгийн дагуу зохих арга хэмжээ авхуулах талаар Улаанбаатар хотын Замын хөдөлгөөний удирдлагын төвд хүргүүлж холбогдох арга хэмжээ тооцуулж байх;

### **Ес. Гэмтлийг тодорхойлох**

9.1. Камер, холбогдох тоног төхөөрөмжийн эвдрэл гэмтлийг Улаанбаатар смарт карт ХХК, нийтийн тээврийн үйлчилгээний аж ахуйн нэгж байгууллагын инженерүүд хамтран тодорхойлж, баримт үйлдэнэ.

9.2. Тээврийн хэрэгсэлд байршуулсан хард диск, мемори картны лацнаас бусад лац хөдөлсөн эсэхийг тодорхойлоход тухайн аж ахуйн нэгж байгууллагаас төлөөллийг заавал байлцуулан үзлэг хийж, баримт үйлдэнэ.

### **Арав. Хүлээх хариуцлага**

10.1. Камер, холбогдох тоног төхөөрөмжид тухайн нийтийн тээврийн үйлчилгээний аж ахуйн нэгж байгууллагын ажилтны санаатай болон санамсаргүй үйлдлээс /шингэн зүйл асгах, төмөр биетээр богино холболт үүсгэх, холбогч утсыг салгах, таслах, тэжээлд хэт өндөр хүчдэл өгөх/ шалтгаалж эвдрэл гэмтэл гарч, хэвийн ажиллагаагүй болсноос үүсэх зардал болон бичлэг хийгдээгүйгээс үүсэх хариуцлагыг тухайн аж ахуйн нэгж, байгууллага /этгээд/ хүлээнэ.

10.2. Камер, холбогдох тоног төхөөрөмжид байршуулсан /журмын 6.2.4-т зааснаас бусад/ лац хөдөлсөн тохиолдолд тухайн нийтийн тээврийн үйлчилгээний аж ахуйн нэгж байгууллага эвдрэл гэмтэлтэй холбоотой гарах зардлыг бүрэн хариуцна.

10.3. Камерыг засварлуулах талаар мэдээллийг аж ахуйн нэгж байгууллага ирүүлээгүй тохиолдолд үүсэх хариуцлагыг холбогдох нийтийн тээврийн үйлчилгээний аж ахуйн нэгж байгууллага хүлээнэ.

10.4 Энэхүү журмын 10.1, 10.2-т зааснаас бусад тохиолдолд үүсэх хариуцлагыг Улаанбаатар смарт карт ХХК хүлээнэ.

10.5. Дуудлага өгсөн боловч хугацаандаа засвар үйлчилгээ хийгээгүй, гэмтэл тодорхойлоогүй тохиолдолд Улаанбаатар смарт карт ХХК нь бичлэг хийгдээгүйгээс үүсэх хариуцлагыг хүлээнэ.

10.6 Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд Цагдаагийн албан хаагч, Автотээврийн хяналтын улсын байцаагч холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.